



## **“ГЕРМЕС ЦЕНТР” ХУВЬЦААТ КОМПАНИ**

### **“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2023 он

“Гермес Центр” ХК-ийн засаглалын кодексийн нэгдсэн үнэлгээ

№	Үндсэн зарчмууд	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Хэрэгжилтийн хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6		100%
4	Аудит хяналтын тогтолцоо	6	5		83%
5	Эрсдэлийн удирлагын тогтолцоо	8	7		88%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын мэдээлэл	6	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх, ашиг	10	10		100%
Нийт авсан оноо/хувь		72	70		97.2%

Дүгнэлт

“Гермес Центр” ХК нь засаглалын тогтолцоогоо сайжруулан Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн зарчимд нийцүүлэн компанийн холбогдох дүрэм, заавар журмуудыг шинэчлэн баталж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа бөгөөд компанийн 2022 оны засаглалын кодексийг үнэлэхэд 97.2% буюу хэвийн буюу эрсдэлгүй гэж үнэлэгдсэн.

“Гермес Центр” ХК-ийн засаглалын үнэлгээний тайлан

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
<i>Кодексийн хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтсон "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнахдаа кодекс дурьдсан зарчмын зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг тайлбар хэсэгт нарийвчлан тайлбарлана.</i>					
<b>НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b> <b>ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.</b>					
	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<i>1.1 Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан тогтооно.</i>	Хэрэгждэг	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг.	2	100%
2	<i>1.2 Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлоготой байна.</i>	Хэрэгждэг	ТУЗ-ийн дэргэдэх "Нэр дэвшүүлэх хороо"-ны ажиллах журам болон "Компанийн залгамж халаа"-ны бодлоготой болно.	2	100%
3	<i>1.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.</i>	Хэрэгждэг	ТУЗ-ийн гишүүдийн хуралд оролцсон ирцээс бусад мэдээллийг үйл ажиллагааны тайланд тусгадаг. Цаашид тайлагналыг дэлгэрэнгүй болгоход анхаарч ажиллана.	2	100%
4	<i>1.4 Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.</i>	Хэрэгждэг	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын журмаар зохицуулдаг.	2	100%
5	<i>1.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Хэрэгждэг	ТУЗ-ийн шинэ гишүүдийг шаардлагатай мэдээ мэдээллээр тогтмол хангадаг бөгөөд компанийн засаглалын сургалтанд бүрэн хамруулдаг.	2	100%

6	<i>1.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Хэрэгждэг	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон ТУЗ-ийн нарийн бичгийн ажиллах журмаар зохицуулдаг.	2	100%
<b>Дүн</b>				<b>12</b>	<b>100%</b>
<b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b> <b>ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.</b>					
7	<i>2.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	Хэрэгждэг	Манай компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй бөгөөд тэдгээрээс 3 нь хараат бус гишүүн байдаг. Компанийн тухай хуулийн 75.4-д заасантай нийцнэ.	2	100%
8	<i>2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам, аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Хэрэгждэг	Аудитын хорооны ажиллах журам болон компанийн дотоод хяналтын заавартай. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дарга ТУЗ-ийн хараат бус гишүүн. Хорооны хуралд гүйцэтгэх захирал болон ажилтнууд урилгаар оролцож болно.	2	100%
9	<i>2.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Хэрэгждэг	Манай компанийн ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо нь 3 гишүүнтэй бөгөөд хорооны үйл ажиллагааны журам болон цалин урамшууллын бодлоготой. Хорооны хуралд гүйцэтгэх захирал болон ажилтнууд урилгаар оролцож болно.	2	100%
10	<i>2.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>	Хэрэгждэг	Манай компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь 3 гишүүнтэй бөгөөд хорооны үйл ажиллагааны журам болон компанийн залгамж халааны бодлоготой. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга биш болно.	2	100%

11	2.5 Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Хэрэгждэг	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд компанийн засаглалыг хөгжүүлэх үүднээс шинээр хороо байгуулах боломжийг тусгасан заалт байдаг.	2	100%
<b>Дүн</b>				<b>10</b>	<b>100%</b>
<b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b> <b>ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана.</b>					
12	3.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгждэг	Компанийн мэдээллийн үйл ажиллагааны журам болон үнэт цаас гаргагчийн мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг зохицуулах журамтай.	2	100%
13	3.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Хэрэгждэг	Манай компани нь засаглалын баримт бичгүүдийг өөрийн компанийн <a href="http://www.hermescenter.mn">www.hermescenter.mn</a> цахим хуудас болон Монголын хөрөнгийн биржийн <a href="http://www.mse.mn">www.mse.mn</a> цахим хуудсанд байршуулан олон нийтэд нээлттэй ил тодоор мэдээлж байна.	2	100%
14	3.3 Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй, хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Хэрэгждэг	Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгадаг.	2	100%
<b>Дүн</b>				<b>6</b>	<b>100%</b>
<b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b> <b>ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.</b>					
15	4.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар	Хэрэгждэг	ТУЗ-ийн дэргэдэх "Аудитын хорооны үйл ажиллагааны журам"-д тусгасан байдаг.	2	100%

	<i>тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.</i>				
16	<i>4.2 Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</i>	Хэсэгчлэн хэрэгжиж байгаа	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, гишүүд оролцож хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг. Цаашид хөндлөнгийн аудиторын төлөөллийг ХЭХ-д оролцуулдаг болно.	1	50%
17	<i>4.3 Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.</i>	Хэрэгждэг	Дараалсан хяналтын тогтолцоог бий болгосон.	2	100%
<b>Дүн</b>				<b>5</b>	<b>83%</b>

**ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**

**ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.**

18	<i>5.1 Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.</i>	Хэрэгждэг	Компанийн эрсдэлийн удирдлагын заавраар зохицуулдаг.	2	100%
19	<i>5.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>	Хэрэгждэг	Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага хариуцдаг.	2	100%
20	<i>5.3 Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн олон нийтэд мэдээлж,</i>	Хэрэгжиж байгаа	Эдгээр асуудлыг жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж, олон нийтэд мэдээлдэг.	1	50%

	<i>тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>				
21	<i>5.4 Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.</i>	Хэрэгждэг	Комплайнсын хяналтыг ТУЗ болон гүйцэтгэх удирдлага хяналт тавьж байна.	2	100%
<b>Дүн</b>				<b>7</b>	<b>88%</b>

**ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН, УРАМШУУЛАЛ**  
**Эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга ил тод байна.**

22	<i>6.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Хэрэгждэг	Манай компани нь ТУЗ-ийн цалингийн төсвийг ХЭХурлаар хэлэлцэн баталж, гүйцэтгэлийг хувьцаа эзэмшигчдэд тайлагнаж хэвшсэн.	2	100%
23	<i>6.2 Компанийн цалин урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.</i>	Хэрэгждэг	Манай компани нь улирал бүр ажилтнуудыг "Ажилтны үнэлгээний хуудас"-аар үнэлж дүгнэдэг. Энэхүү шалгуур үзүүлэлтийг "Компанийн цалин урамшууллын бодлого" баримт бичигт тусгасан.	2	100%
24	<i>6.3 Компанийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	Хэрэгждэг	"Компанийн цалин урамшууллын бодлого"-оор зохицуулдаг.	2	100%
<b>Дүн</b>				<b>6</b>	<b>100%</b>

**ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ**  
**Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ.**

25	<i>7.1 Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>	Хэрэгждэг	ТУЗ-ийн 2022 оны 08-р сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцэн баталсан "Компанийн ёс зүйн дүрэм"-д тусгаж өгсөн.	2	100%
26	<i>7.2 Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн</i>	Хэрэгждэг	Компанийн үйл ажиллагааны тайланд тодорхой хэмжээгээр тусгадаг.	2	100%

	<i>хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>				
27	<i>7.3 Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	Хэрэгждэг	Компанийн <a href="http://www.hermescenter.mn">www.hermescenter.mn</a> цахим хуудсыг байнга шинэчилж, холбогдох мэдээ мэдээллийг байршуулан хувьцаа эзэмшигчдэд болон сонирхогч этгээдүүдэд хүргэдэг.	2	100%
28	<i>7.4 Компанийн ажилтнуудын санал хүсэлт гомдлыг авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Хэрэгждэг	Компанийн ажиллагсдын ажлын байранд мөрдөх хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд асуудлыг шийдвэрлэдэг.	2	100%
<b>Дүн</b>				<b>8</b>	<b>100%</b>

#### **НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ**

**ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно.**

29	<i>8.1 Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Хэрэгждэг	ТУЗ-ийн 2022 оны 08-р сарын 26-ны өдрийн хурлаар "Компанийн ёс зүйн дүрэм"-ээр зохицуулна.	2	100%
30	<i>8.2 Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.</i>	Хэрэгждэг	ТУЗ-ийн 2022 оны 08-р сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцэн баталсан "Компанийн комплайнсын хяналтын заавар"-аар шүгэл үлээгчийн тогтолцоог бүрдүүлсэн.	2	100%
31	<i>8.3 Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, (дэмжихгүй байх) хандив өргөх (өргөхгүй байх) талаар зохицуулна.</i>	Хэрэгждэг	ТУЗ-ийн 2022 оны 08-р сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцэн баталсан "Компанийн ёс зүйн дүрэм"-ээр зохицуулагдана.	2	100%
<b>Дүн</b>				<b>6</b>	<b>100%</b>

#### **ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШИГ**

**Компанийн болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.**

32	9.1 Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	Хэрэгждэг	Жил, хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд багтаан МХБиржийн цахим хуудас болон өөрийн компанийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол хүргэдэг.	2	100%
33	9.2 Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Хэрэгждэг	Одоогоор өөрийн компанийн цахим хуудас болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэж байна. Шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийг хүлээн авч холбогдох мэдээллийг тогтмол өгч хэвшсэн болно.	2	100%
34	9.3 Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцлийг бүрдүүлнэ.	Хэрэгждэг	Хувьцаа эзэмшигчид хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрэн хангахыг хичээн ажиллаж байна.	2	100%
35	9.4 Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Хэрэгждэг	"Компанийн тухай хууль", "Компанийн дүрэм"-д заасны дагуу эрхээ хэрэгжүүлэх нөхцөл хангагдсан.	2	100%
36	9.5 Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Хэрэгждэг	"Компанийн ёс зүйн дүрэм"-ээр зохицуулдаг. Ашиг сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийхээс зайлсхийж ажилладаг.	2	100%
<b>Дүн</b>				<b>10</b>	<b>100%</b>
<b>Нийт дүн</b>				<b>70</b>	<b>97.2%</b>

Жич: Тус компанийн “Компанийн засаглалын кодекс”-той холбоотой бодлогын баримт бичиг, заавар журмуудтай дараах холбоосоор танилцана. уу. <https://www.hermescenter.mn/CorporateGovernance->